



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Мандах Их Сургууль Тайгам Алтай группын хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа

Мандах Их Сургууль нь төрийн болон хувийн хэвшлийн олон байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд эдгээр байгууллагуудтай Түншлэлийн гэрээ байгуулан, гэрээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган мөрдөн ажилладаг уламжлалтай. Өнөөдөр тус сургууль Тайгам Алтай группын менежмент, хүний нөөц хариуцсан Пексар Интернэйшнл ХХК-тай хамтран ажиллах Түншлэлийн гэрээ байгууллаа. Гэрээ байгуулах албан ёслолд Мандах Их Сургуулийн захирал, дэд захирлууд, Пексар Интернэйшнл ХХК-ийн гүйцэтгэх захирал болон албаны хүмүүс оролцлоо.

Энэхүү гэрээнд зааснаар:

Оюутан дадлагажуулах

Төсөлт хөтөлбөр хэрэгжүүлэх

Төгсөгчдөөс ажилд сонгон ажиллуулах

Старт ап компани үүсгэн хөгжүүлэх

Пексар Интернэйшнл ХХК-ийн ажиллагчдыг урт, богино хугацааны сургалтанд хамруулах. Харилцан хөнгөлөлттэй ажил үйлчилгээ үзүүлэх зэрэг олон талаар хамтран ажиллахаар боллоо.





Эрдэм шинжилгээ, судалгаа

Оюутны эрдэм шинжилгээний хуралд дэд байр эзэллээ

МУБИС-ийн 70 жилийн ойг угтаж гурав дахь жилдээ МУБИС-Боловсрол судлалын сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимээс “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсрол, хөгжил, оролцоо” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 02 сарын 28-нд цахимаар зохион байгууллаа.

Тус хуралд Мандах их сургуулийн НББ-Статистик 3-р дамжааны оюутан, “Science Hub” клубын гишүүн Г. Энхжин, Б. Гүнсэнхорол нар “Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол, нөлөөлөх зарим хүчин зүйлийн судалгаа” сэдэвт илтгэлээрээ “ДЭД БАЙР”-т шалгарч, “Интерном” дэлгүүрээс 100 мянган төгрөгийн ном авах эрхээр шагнуулав.



Эрдэм шинжилгээ, судалгаа

“Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй-2021” сургалт семинар зохион байгуулагдлаа

Энэхүү сургалт семинарын зорилго нь бакалавр болон магистрын хөтөлбөрийн оюутнуудад сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны талаар хэрэгжүүлж буй бодлогыг танилцуулах, эрдэм шинжилгээний ажлын ач холбогдлыг ойлгуулах, судалгааны арга зүй эзэмших, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, бакалаврын болон магистрын дипломын бүтэц, эрдэм шинжилгээний стандарт, хуулбарлалтыг илрүүлэх програмын ашиглалт нэмэгдүүлэх гэх мэт асуудлыг авч үзэж, судалгааны ажлын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдлээ.

Мандах Их Сургуулийн захиргаанаас энэхүү сургалт семинарыг уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн ба энэ удаагийн хурал 2021 оны 4 сарын 09-ны өдөр онлайн хэлбэрээр zoom програм ашиглан зохион байгуулагдаж, бакалавр, магистрын хөтөлбөрийн 450 гаруй суралцагсад хамрагдлаа. Уг сургалт семинарыг тус сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ч. Төрбадрах, сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны хорооны дарга, доктор А. Наранцэцэг, Ахисан түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор С. Цолмон, Хөтөлбөр хариуцсан ажилтан Б. Мөнхбат нар удирдан зохион байгуулж, илтгэл тавьж, суралцагчдын сонирхсон асуултанд хариуллаа. Түүнчлэн гадаадын хамтын ажиллагаатай их, дээд сургуулиудтай хэрэгжүүлж буй хос болон хамтарсан хөтөлбөрүүд, олон улсын мэргэжлийн англи хэлний шалгалтын талаар танилцуулж оюутнуудын асуултад дэлгэрэнгүй хариулт өглөө

Эрдэм шинжилгээ, судалгаа

Оюутны эрдэм шинжилгээний хуралд дэд болон гутгаар байрт шалгарлаа

2021 оны 5-р сарын 7 ны өдөр Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын институтаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бакалаврын түвшний оюутнуудын эрдэм шинжилгээний хурал онлайн хэлбэрээр зохион байгуулагдлаа. Энэхүү хуралд оролцогч оюутнууд мэргэжлийн ирээдүйн чиг хандлага, аудитын салбарын хөгжил, санхүүгийн менежмент, улсын салбарын санхүүгийн менежмент зэрэг сэдвийн хүрээнд илтгэлүүдээ хэлэлцүүлээ. Эрдэм шинжилгээний хуралд нийт 5 сургуулийн 10 илтгэл шалгарч хэлэлцүүлэгдсэн бөгөөд Мандах Их Сургуулийн оюутнууд амжилттай оролцов.

ДЭД БАЙРТ: “Ковид-19 цар тахлын үеэрх хувьцаат компаниудын ашигт ажиллагаа” сэдвээр НББ-Статистик IY курсын оюутан Ц.Намуун, удирдагч багш А.Наранцэцэг (Ph.D)

ГУТГААР БАЙРТ: “Ирээдүйн нягтлан бодогчдоос шаардах ур чадваруудыг тодорхойлох нь” сэдвээр

НББ-Статистик IY курсын оюутан Г.Энх-Отгон, Г.Мягмарсүрэн, Б.Алтанзул, удирдагч багш А.Наранцэцэг (Ph.D)



Үйл явдлууд

Гадаад хэлний сургалтын онол, арга зүйн семинар амжилттай зохион байгуулагдалаа

Мандах их сургуулийн Гадаад хэлний тэнхимээс уламжлал болгон зохион байгуулдаг “Гадаад хэлний сургалтын онол, арга зүйн семинар – 2021” сэдэвт онол, арга зүйн семинарыг Zoom платформ ашиглан цахим буюу “Webinar” хэлбэрээр 2021 оны 3 сарын 27-ны өдөр 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Тус сургуулийн захирал, профессор Г. Нанжид семинарыг нээж хэлсэн үгэндээ семинарын цар хүрээ тэлж оролцогч, сонирхогчдын тоо өсч байгаа болон одоогийн нөхцөл байдалтай уялдуулан цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа нь магадгүй илүү чанартай, хүртээмжтэй байлгахад давуу тал болж байгааг дурьдаад гадаад хэлний сургалтын хөгжилд хувь нэмрээ оруулж яваа эрдэмтэн судлаач, багш нарыг идэвхтэй оролцож, илтгэл хэлэлцүүлж буйд нь талархлаа илэрхийлж, семинарын үйл ажиллагаанд амжилт хүслээ. Уг семинарт Монгол улсын их, дээд сургууль, коллеж, ЕБС-ийн төлөөлөл 300 гаруй эрдэмтэн судлаач, профессор багш нар оролцож англи хэлний сургалтад тулгамдаж буй асуудал, түүнийг сайжруулах арга зам, орчин үеийн чиг хандлага, дэвшилтэт технологийн талаар практикт суурилсан судалгааны үр дүнгээ хэлэлцэн, арга туршлагаа хуваалцахын зэрэгцээ цаашдын хамтын судалгаа, сургалтын талаар санал бодлоо солилцон “Гадаад хэлний сургалтын онол, арга зүйн семинар-2021”-ын зохион байгуулалт, ач холбогдол, цаашид ямар чиглэлийг хамрах, цахим хэлбэрээр зохион байгуулах нь үр дүнтэй эсэх талаар санал асуулгад нийт оролцогчид хамрагдсан байна.

Мандах ИС-ийн ГХТ-ийн эрхлэгч Б. Баатарцогт хурлын үйл ажиллагааг хааж, зочин илтгэгч нар болон нийт оролцогч эрдэмтэн багш нарт хандан талархлаа илэрхийлж, ирэх жилийн семинарт дахин оролцохыг урьснаар хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

**“ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ОНОЛ,
АРГА ЗҮЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА”**
СЭДЭВТ ОНЛАЙН СЕМИНАР 2021

Зочин оролцогчид

- М. Саруул-Эрдэнэ**
АНУ-ын Конгрессын Номын Сангийн Монгол номын мэргэжилтэн, Доктор /Ph.D/
- Т. Алтанцэцэг**
АНУ-ын ЭСЭ-ны Олон Нийтэй Харилцах Албаны Англи хэлний хөтөлбөрийн зохицуулагч
- Scott Poteet**
АНУ-ын ЭСЭ-ны мэргэжилтэн багш
- Б. Тунгалаг**
МУБИС Дэд профессор Доктор /Ph.D/
- Н. Нансалмаа**
МУИС Профессор Доктор /Ph.D/
- Т. Оосун-Эрдэнэ**
Мандах ИС Гадаад хэлний тэнхимийн багш

3-р сарын 27 Бямба гарагт 10:00 цагт

ПЛАТФОРМ
GOOGLE MEET

☎ 976 8586244
☎ 976 99138048

**“ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ОНОЛ,
АРГА ЗҮЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА”**
СЭДЭВТ ОНЛАЙН СЕМИНАР 2021

Эрдэм шинжилгээ, судалгаа

Оюутны эрдэм шинжилгээний хуралд дэд байр, гутгаар байр, тусгай байр эзэлсэн амжилтыг үзүүллээ

2021.03.26-04.09-ны өдөр ШУТИС-ын оюутны Эрдмийн XX чуулганы эдийн засаг, менежментийн салбар хуралдаан, “Эрдмийн шувуу” цомын төлөөх үндэсний хэмжээний оюутны эрдэм шинжилгээний XVIII-р бага хурал “Дижитал шилжилт – Байгууллагын асуудлууд” (сургалт, судалгаа) сэдвийн хүрээнд их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцаж буй оюутнуудын дунд болж өндөрлөлөө. Энэхүү хурал нь 2 үе шаттай зохион байгуулагдаж, 1-р шатанд нийт 5 сургуулийн 55 оюутны 40 илтгэл ирүүлснээс 2-р шатанд 10 илтгэл шалгарч 2021.04.09-ны өдөр цахимаар амжилттай хэлэлцүүлэн шилдгүүдийг тодрууллаа. Тус хуралд Мандах Их сургуулийн НББ-Банк болон НББ-Статистик хөтөлбөрийн 3, 4-р дамжааны оюутнууд амжилттай оролцлоо.


- НББ-Банк 4-р дамжааны оюутан Ц.Сарангуа “Банкны зээлийн сувгийн бодит эдийн засаг дахь нөлөөллийг VECM, GMM загвараар үнэлэх нь” сэдэвт илтгэлээр дэд байр, өргөмжлөл 500,0 мянган төгрөг /Удирдагч багш магистр Ж.Гантулга/
- НББ-Статистик 4-р дамжааны оюутан Г.Мягмарсүрэн, НББ-Статистик 3-р дамжааны оюутан Б.Баянжаргал нарын хамтарсан “Байгууллагын гүйцэтгэлийг хэмжих түлхүүр үзүүлэлтийн (KPI) асуулгын хүчин төгөлдөр, найдвартай байдлын судалгаа” сэдэвт илтгэлээр гутгаар байр, өргөмжлөл, 300,0 мянган төгрөг /Удирдагч багш, доктор А.Наранцэцэг/
- НББ-Банк 4-р дамжааны оюутан Э.Бат-Оргил, Ц.Сарангуа нарын хамтарсан “Гүн сургалтын аргад тулгуурлан буруу илэрхийлэлтэй санхүүгийн тайланг илрүүлэх FRAUD загвар боловсруулах нь” сэдэвт илтгэлээр тусгай байр, өргөмжлөл үнэ бүхий зүйл /Удирдагч багш магистр Ж.Гантулга/

НББ-Банк 4-р дамжааны оюутан Э.Бат-Оргил “Орчин үеийн машин сургалтын зарим аргуудад тулгуурлан зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэх нь” сэдэвт илтгэлээр тусгай байр, өргөмжлөл, үнэ бүхий зүйл /Удирдагч багш доктор С.Цолмон, магистр Ж.Гантулга/



Докторын зэрэг амжилттай хамгааллаа

Тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш Б. Батчимэг Унгар улсын "University of Debrecen"-ийн сургуульд 2018-2021 онд докторантурт суралцан 2021 оны 2-р сарын 25-нд "FINANCIAL PERFORMANCE ANALYSIS OF STOCK EXCHANGE LISTED MONGOLIAN COMPANIES" сэдвээр докторын зэрэг амжилттай хамгааллаа. Докторын зэрэг амжилттай хамгаалсан багш Б. Батчимэгтээ баяр хүргэж цаашдын сургалт, эрдэм шинжилгээний ажилд нь улам өндөр амжилт гаргахыг нийт сургуулийн хамт олны нэрийн өмнөөс хүсэн ерөөе.



Мандах Их Сургуулийн Ахисан түвшний сургууль байгуулагдлаа

Тус сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 01 тогтоолоор Мандах Их Сургуулийн бүрэлдэхүүний “Ахисан түвшний сургууль” байгуулагдах шийдвэр гаргалаа.

Энэхүү сургууль нь магистр, докторын сургалт, судалгааны хөтөлбөрийг сайжруулах, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулах, ахисан түвшинд мэргэжил дээшлүүлэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, магистрант, докторантын сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

Мандах Их Сургуулийн захирлын 2021 оны 03-р сарын 10-ны өдрийн Б/06-р тушаалаар Ахисан түвшний сургуулийн захирлаар Доктор, дэд профессор С.Цолмонг томилж, үүрэгт ажлаа хүлээн авлаа.

Үйл явдлууд

Англи хэлний онлайн олимпиадыг зохион байгууллаа

Мандах Их Сургуулийн ГХТ-ээс 1-р курсийн оюутнуудын идэвхи сонирхлыг нэмэгдүүлэх, цахим орчинд өөрсдийгөө сорих, англи хэлний мэдлэг, ур чадвар, амжилтаа бататгах зорилгоор “Англи хэлний онлайн олимпиад”-ыг гурав дахь жилдээ 2021.04.28-30-ны өдрүүдэд Moodle болон Google meet ашиглан, цахимаар зохион байгууллаа. Олимпиадын 1-р шатанд 248 оюутан, 2-р шатанд эхний шатнаас оноогоор тэргүүлсэн 28 оюутан, нийт давхардсан тоогоор 276 оюутан оролцож, англи хэлний мэдлэг, ур чадвараа сорьсноос дараах оюутнууд шагналт байранд шалгарлаа.

Ө.Энхжаргал	Санхүүгийн менежмент	74 оноо	I Байр
Ч.Эрдэнэсоёл	НББ-Англи хэл	73 оноо	II Байр
О.Төгсбаяр	Програм хангамж	70 оноо	III Байр




Үйл явдлууд

“Инженерийн механик-2021” олимпиад зохион байгуулагдлаа

Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимээс санаачлан Инженерийн механик-2021 олимпиадыг 2021 оны 04 сарын 30-ны өдөр сургуулийн цахим сургалтын систем ашиглан, Live хэлбэрээр инженерийн хөтөлбөрийн II, III дамжааны оюутнуудын амжилттай зохион байгууллаа. Энэхүү олимпиадыг нээж Мандах Их Сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал, дэд профессор, доктор Ч. Төрбадрах үг хэллээ. Энэхүү олимпиад нь инженерийн хөтөлбөрийн оюутнуудын механик инженерийн мэргэжлийн суурь хичээлүүдийн онол, практикийн мэдлэг, чадвар, инженерийн бодлого бодох арга зүйг дээшлүүлэх зорилготой юм.

Энэ удаагийн олимпиадад дараах оюутнууд амжилттай оролцож өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Үүнд:

- I байранд- Н.Цогжавхлан /ИЭЗ-III/
- II байранд- Ө.Гангамаа /ИЭЗ-III/
- III байранд- Б.Туяацэцэг /ИЭЗ-II/
- Тусгай байранд- Б.Жаргалмаа /ИЭЗ-III/



Гадаад хамтын ажиллагаа

Японы Тохоку их сургуулиас гадаадын их дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан онлайн арга хэмжээний хаалтын үйл ажиллагаанд Мандах их сургуулийн оюутнууд оролцлоо

Японы Тохоку их сургуулиас гадаадын их дээд сургуулийн оюутнуудад зориулсан онлайн уулзалт, арга хэмжээг 2021 оны 4-р сарын 8 -наас 5-р сарын 27-ныг хүртэл зохион байгуулсан билээ. Энэхүү арга хэмжээний хаалтын үйл ажиллагаа өчигдөр онлайн хэлбэрээр зохион байгуулагдаж, амжилттай болж өндөрлөлөө.

Дэлхийн өнцөг булан бүрээс оролцсон оюутнууд бүтэн хагас сарын турш нэгэн сэдвийн дор нэгдэн, хэлэлцүүлэг өрнүүлэх, санал бодлоо солилцох, бие биенээсээ суралцах зэргээр өөр хоорондоо харилцаж, туршлагаа хуваалцсан юм.

Хаалтын арга хэмжээнд бүлэг болон хуваагдсан оюутнууд “Дэлхийн нийтийг хамарсан цар тахал улс орнуудад хэрхэн нөлөөлж байна вэ?” гэсэн ерөнхий сэдвийн дор өөрсдийн улс орны жишээн дээр тайлбарласан илтгэлийг хэлэлцүүлээ. Нийт 13 илтгэл хэлэлцүүлснээс бүлгээ төлөөлөн, Мандах их сургуулийн Магистрын хөтөлбөрийн оюутан Т. Намуун “Улс орнуудын цар тахалтай тэмцэж буй арга хэрэгсэл” сэдвээр, Санхүү, менежментийн 2-р дамжааны оюутан Э. Цацрал “Хөдөлмөр эрхлэлт ба эдийн засагт Ковид-19 цар тахлын нөлөөлөл” сэдвээр тус тус илтгэл тавьж, амжилттай хэлэлцүүлээ.

Арга хэмжээнд ХБНГУ, Дани, Румын, Грузин, Польш, Тунис, Индонези, Япон, Колумб, Вьетнам, БНХАУ, Итали зэрэг 13 орны их дээд сургуулийн бакалавр, магистрын хөтөлбөрийн 40 гаруй оюутнууд оролцсон бөгөөд зохион байгуулагч Тохоку их сургуулийн зүгээс энэхүү арга хэмжээнд өндөр ач холбогдол өгч, илтгэл бэлтгэж оролцсон нийт оюутнуудад талархал илэрхийллээ.

Манай улсад Ковид-19 цар тахлын улмаас бий болсон хүндрэл бэрхшээл, сөрөг асуудлууд бусад орнуудад нэгэн адил тохиолдож байгааг илтгэлүүдээс тодорхой харагдаж байлаа.

CHINESE PREVENTATIVE MEASURES

To contain the outbreak, Wuhan is lock down:

1. Strict isolation measures in Hubei Province
2. Medical personnel and material support from the whole country.
3. Quickly built 2 infectious disease hospitals and several mobile hospitals

All people in Wuhan carried out acid testing, and Wuhan begins its Coronavirus Lockdown.

Timeline:

- 12/27/2019: Wuhan found the pneumonia of unknown cause. China reported the epidemic situation to WTO and conducts etiological and epidemiological investigation.
- 01/20/2020: The number of new local cases has gradually dropped to single digits. The government announced to extend the Chinese Spring Festival holiday and to postpone the reopening of schools.
- 02/21/2020: The national epidemic control has been implemented. The epidemic situation is sporadic, and the caused by sporadic cases in some areas, which basically control.
- 03/18/2020
- 04/29/2020

Mongolia

Since the beginning of the pandemic in the first half of 2020, Mongolian economy has suffered immensely.

In fact, from March to October 2020, Mongolian government had imposed a strict to moderate lockdowns in order to prevent from spreading Covid-19.

However, it is important to note that at that time Mongolia had no cases of local transmission.

In order to see the impact of Covid-19 by industries and the employment rate we referred to a research conducted by Mongolian National Statistics Committee.

Impact of Covid-19 by industries

Industry	Strong	Moderate	No	Not sure
Education	100	0	0	0
Healthcare	100	0	0	0
Travel	100	0	0	0
Food production	100	0	0	0
Transportation	100	0	0	0
Commerce	100	0	0	0
Mining	100	0	0	0
Construction	100	0	0	0
Others	100	0	0	0

Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургуулийн багш, ажилтнууд Ирландын Дублин хотын их сургуулийн бизнесийн англи хэлний онлайн сургалтад амжилттай хамрагдлаа

Багш, ажилтнуудын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Ирланд улсын Дублин хотын их сургуультай хамтран Бизнесийн англи хэлний эрчимжүүлсэн онлайн сургалтад багш, ажилтнуудаа хамруулах ажлыг 2021 оны 3-р сард амжилттай зохион байгууллаа. Сургалтад Мандах их сургуулийн 8 багш, ажилтнууд хамрагдсан ба долоо хоногт 5 удаа өдөрт 3 цагийн сургалт хамрагдсан.

Тус онлайн сургалтаар багш, ажилтнууд англи хэлний ярианы ур чадвар, тэр дундаа бизнесийн орчны харилцаа, яриа хэлцэл, уулзалт, илтгэл тавих, утсан болон цахим шуудангийн харилцаа холбоог англи хэл дээр гүйцэтгэх ур чадварыг эзэмших юм. Уг сургалтанд олон улс орнуудын англи хэл суралцагсадтай хамт нэг анги болж, бие биенээсээ суралцах, өөр хоорондоо англи хэлээр харилцах боломж бүрдсэн нь сургалтыг улам үр дүнтэй болголоо. Амжилттай суралцсан багш, ажилтнуудад Дублин хотын их сургуулиас сертификат олгосон байна.



Шагнал урамшуулал

Мандах Их Сургуулийн багш, ажилтнууд Төрийн одон, медалиар шагнууллаа

Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жил, Ардын хувьсгалын 100 жил, Ардчилсан хувьсгалын 32 жилийн ой, Монголын үндэсний уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 14 дүгээр зарлигаар Мандах Их Сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Нацагдорж, Сургалт эрхэлсэн дэд захирал Ч.Төрбадрах нар “Алтан гадас” одонгоор, Захирлын ажлын албаны дарга С.Энхтуяа “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар тус тус шагнагдаж, хийж бүтээсэн ажил, хөдөлмөрөө төрөөр үнэлүүллээ.



Мандах Их Сургуулийн багш нар Төрийн одон, медалиар шагнууллаа

Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жил, Ардын хувьсгалын 100 жил, Ардчилсан хувьсгалын 32 жилийн ойг тохиолдуудан Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын зарлигаар Мандах Их Сургуулийн төрийн дээд Алтан гадас одонгоор Эдийн засаг, бизнесийн тэнхимийн дэд профессор, доктор, Г. Билгээ, Хөдөлмөрийн хүндэт медалиар Гадаад хэлний тэнхимийн дэд профессор Т. Сумъяа нар тус тус шагнагдаж, хийж бүтээсэн ажил, хөдөлмөрөө төрөөр үнэлүүллээ.

Үйл явдлууд

ISO 21001:2018 стандартын магадлах аудитыг амжилттай хийлгэлээ

Тус сургууль нь 2020 онд боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 олон улсын стандартыг нэвтрүүлсэн Монголын анхны боловсролын байгууллага болсон бөгөөд Энэтхэгийн “IRCLASS” менежментийн баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээгээ гардан авсан.

Энэхүү стандартыг хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэж, дүгнэх магадлах аудитыг жил бүр хийдэг бөгөөд энэ жилийн магадлах аудитыг олон улсын байгууллага 2021 оны 6 сарын 30-нд цахимаар хийлээ.

Аудитаар үл тохирол гараагүй буюу менежментийн тогтолцоо сайн хэрэгжиж байна гэж дүгнэлээ.

Магадлах аудитад бэлтгэж, тайлан хамгаалах ажлын хэсгийн багийн ахлагчаар дэд захирал Ч.Төрбадрах багийн гишүүдэд С.Энхтуяа, Д.Доломжав, З.Булганаа, Б.Мөнхбат нар амжилттай сайн ажиллалаа.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалт эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Номын санч /
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn